

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалан сумын “Суурин дулаан” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2025/005/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот	2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: О.Энхтөр Утас: 95343496 Цахим хаяг: enkhturo@audit.gov.mn
--	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есенбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

**ЖАРГАЛАН СУМЫН “СУУРИН ДУЛААН”  
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ Р.МЯГМАРДОРЖ  
ТАНАА**

2025. 03.15 № 111

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Жаргалан сумын “Суурин дулаан” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд дулааны үнэ, тарифын зөрүүнээс хамаарч авлага нэмэгдсэн, 2,947.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр байгууллагын гадна орчны тохижилтын ажил хийсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 70 дугаар тогтоолоор байгууллагын үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөг батлуулан үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 82.0 хувьтай биелүүлсэн байна.

Тайлант онд дулааны үнэ, тарифын зөрүүнээс хамаарч 141,346.8 мянган төгрөгийн авлага, 63,813.8 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

**8225020313**

### **Бусад асуудал**

Тайлант онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 14 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>58,991,456.70</b>	<b>172,985,786.17</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>32,253,749.18</b>	<b>9,458,367.21</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>4,183,843.90</b>	<b>141,346,873.50</b>
33401	Дансны авлага /ТӨҮГ/	3,170,510.00	141,080,555.60
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	276,317.90	266,317.90
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>22,553,863.62</b>	<b>22,180,545.46</b>
354	Хангамжийн материал	22,553,863.62	22,180,545.46
35410	Бичиг хэргийн материал	645,363.64	487,272.74
35420	Аж ахуйн материал	17,833,954.53	18,895,090.90
35440	Түлш, шатах тослох материал	4,074,545.45	2,798,181.82
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,111,056,042.95</b>	<b>2,082,202,226.38</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,111,056,042.95</b>	<b>2,082,202,226.38</b>
392	Биет хөрөнгө	2,104,500,755.30	2,075,846,938.74
	Барилга, байгууламж, орон сууц	2,164,088,483.54	2,166,935,483.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	(206,487,684.19)	(269,677,967.81)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	242,694,457.91	243,346,795.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,794,501.96)	(64,757,372.90)
393	Биет бус хөрөнгө	6,555,287.65	6,355,287.64
39303	Бусад биет бус хөрөнгө	7,072,000.00	7,072,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(516,712.35)	(716,712.36)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,170,047,499.65</b>	<b>2,255,188,012.55</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>153,658.59</b>	<b>63,813,796.66</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>153,658.59</b>	<b>63,813,796.66</b>
413	Өглөг	153,658.59	63,813,796.66
4136	Бусад өглөг	153,658.59	63,813,796.66
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	90,360.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	153,658.59	16,168,433.61
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		12,137,480.02
41366	Дансны өглөг /ТӨҮГ/		35,417,523.03
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,169,893,841.06</b>	<b>2,191,374,215.89</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,169,893,841.06	2,191,374,215.89
512	Хуримтлагдсан үр дүн	2,169,893,841.06	2,191,374,215.89
51210	Өмнөх үеийн үр дүн	1,889,469,786.11	2,169,893,841.06
51220	Тайлант үеийн үр дүн	280,424,054.95	21,480,374.83
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,170,047,499.65</b>	<b>2,255,188,012.55</b>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>693,792,707.28</b>	<b>529,569,028.17</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>693,792,707.28</b>	<b>529,569,028.17</b>
120	Нийтлэг татварын бус орлого	693,792,707.28	529,569,028.17
120002	Хүүгийн орлого	7,471.46	71,123.44
120009	Бусад орлого		155,000.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	350,795,835.82	477,442,904.73
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	342,989,400.00	51,900,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>412,768,652.34</b>	<b>508,088,653.34</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>412,768,652.34</b>	<b>508,088,653.34</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>412,768,652.34</b>	<b>508,088,653.34</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	412,768,652.34	508,088,653.34
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	293,199,840.26	366,124,809.04
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	118,398,464.92	140,841,531.95
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/		
210813	Бусад зардал /ТӨҮГ/	1,170,347.16	1,122,312.35
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>281,024,054.94</b>	<b>21,480,374.83</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>281,024,054.94</b>	<b>21,480,374.83</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)</b>	<b>382,804,880.86</b>	<b>387,633,113.04</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>382,787,409.40</b>	<b>387,406,989.60</b>
110	Орлогын албан татвар	382,787,409.40	387,406,989.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	382,787,409.40	387,406,989.60
110002	Үйл ажиллагааны орлого	382,787,409.40	387,406,989.60
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,471.46</b>	<b>226,123.44</b>
120	Нийтлэг татварын бус орлого	17,471.46	226,123.44
120009	Бусад орлого	10,000.00	155,000.00
120014	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого /ТӨҮГ/	7,471.46	71,123.44
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (-)</b>	<b>384,360,514.16</b>	<b>401,981,495.01</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>384,360,514.16</b>	<b>401,981,495.01</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>384,360,514.16</b>	<b>401,981,495.01</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,315,868.02	161,884,119.96
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	113,315,868.02	161,884,119.96

**Жаргалан сумын "Суурин дулаан" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,420,679.15	40,535,629.45
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	37,420,679.15	40,535,629.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,089,828.15	26,556,227.69
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	23,089,828.15	26,556,227.69
2104	Хангамж, бараа материалын зардал	169,771,050.00	129,911,450.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	151,959,600.00	122,433,100.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	17,811,450.00	7,478,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,763,088.84	43,094,067.91
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	31,939,821.79	35,014,684.71
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	8,823,267.05	8,079,383.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(1,555,633.30)</b>	<b>(14,848,381.97)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (-)</b>	<b>2,514,000.00</b>	<b>7,947,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,514,000.00</b>	<b>7,947,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	2,514,000.00	7,947,000.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	2,514,000.00	7,947,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(2,514,000.00)</b>	<b>(7,947,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(4,069,633.30)</b>	<b>(22,795,381.97)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,333,382.48	32,253,749.18
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,253,749.18	9,458,367.21

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

**(төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан Ашиг	Нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,007,460,321.57	(7,974,885.26)	1,999,485,436.31
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,007,460,321.57	(7,974,885.26)	1,999,485,436.31
C07	Тайлант үеийн үр дүн	-	170,408,404.75	170,408,404.75
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,007,460,321.57	162,433,519.49	2,169,893,841.06
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,007,460,321.57	162,433,519.49	2,169,893,841.06
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,007,460,321.57	162,433,519.49	2,169,893,841.06
D08	Тайлант үеийн үр дүн	-	21,480,374.83	21,480,374.83
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,007,460,321.57	183,913,894.32	2,191,374,215.89

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

**(төгрөгөөр)**

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
<b>ОРЛОГО</b>	<b>476,947,600.00</b>	<b>477,669,028.17</b>	<b>(721,428.17)</b>	<b>100%</b>
Үйл ажиллагааны орлого	476,947,600.00	477,442,904.73	(495,304.73)	100%
Бусад орлого		226,123.44	(226,123.44)	
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	338,835,200.00	329,135,240.00	9,699,960.00	100%
1.3 Нийт ашиг	138,112,400.00	148,533,788.17	(10,421,388.17)	108%
Тэтгэмж шагнал урамшуулал	3,590,000.00	1,122,300.00	2,467,700.00	31%
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	88,328,400.00	88,600,000.00	(271,600.00)	100%
Хөрөнгө оруулалтын зардал	8,000,000.00	7,947,000.00	53,000.00	106%
Удирдагын зардал/борлуулалт маркетингийн зардал	81,397,200.00	81,284,113.34	113,086.66	88%
1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	181,815,600.00	170,253,413.34	11,562,186.66	94%
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	(43,703,200.00)	(30,419,625.17)	(13,283,574.83)	70%
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	(43,703,200.00)	(30,419,625.17)	(13,283,574.83)	70%
Татвар төлөх ашиг алдагдал	(43,703,200.00)	(30,419,625.17)	(13,283,574.83)	70%
4. Татварын дараах ашиг алдагдал	(43,703,200.00)	(30,419,625.17)	(13,283,574.83)	70%
Авлага		141,346,873.50	(141,346,873.50)	0%
Өглөг		63,813,796.66	(63,813,796.66)	0%

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

**3.1** Аудитаар 500.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- Тайлант онд 8,447.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг 500.0 мянган төгрөгөөр дутуу орлого авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Залруулагдаагүй нийт 1,940.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,940.9 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.2 Албан шаардлага

1. Албан хаагчдын цалинг нийгмийн даатгалын байгууллагад тайлагнахдаа 1,940.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө", 32 дугаар зүйлийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Нийгмийн даатгалд дутуу тайлагнасан цалингийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант онд 141,346.8 мянган төгрөгийн авлага, 63,813.8 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Санхүүгийн тайланд тусгасан авлага, өглөгийг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулса		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж					
		Тоо		Дүн		Тоо		Дүн		Залруулсан		Залруулаагүй		Тоо		Дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14				
Жаргалан сумын "Суурин дулаан" ААТҮГ	Тайлант онд 8,447.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг 500.0 мянган төгрөгөөр дутуу орлого авсан байна.	1	500.0	1	500.0	-	-	1	500.0	-	-	-	-				
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>500.0</b>	<b>1</b>	<b>500.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>500.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо		Дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Жаргалан сумын "Суурин дулаан" ААТҮГ	Албан хаагчдын цалинг нийгмийн даатгалын байгууллагад тайлагнахдаа 1,940.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Тайлант онд 141,346.8 мянган төгрөгийн өглөг авлага, 63,813.8 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.	1	1,940.9	-	-	1	1,940.9	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>		<b>2</b>	<b>1,940.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>1,940.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>